



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 03 сарын 06 өдөр

Дугаар А/89

Хэрлэн сум

Хүндэтгэл үзүүлж, хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.1, 58.2.17, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан журмын 2.3 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигаар батлагдсан Монгол Улсын цол хүртээх, одон, медалиар шагнах журам, Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын уугуул, Монгол Улсын гавьяат малчин Гомбоцэрэнгийн Сампилд Монгол Улсын Хөдөлмөрийн баатар цолоор шагнуулсанд хүндэтгэл үзүүлж, хөрөнгө зарцуулсугай

2. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Хүндэтгэл үзүүлэхэд шаардагдах зардлын 3,362,500 /Гурван сая гурван зуун жаран хоёр мянга таван зуун/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн шагнал урамшуулал, буцалтгүй тусламжийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

01 468